



БҮРТГЭЛ, ЭЛСЭЛТЭД ҮЗҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД

Эцэг, эхүүд өөрсдийн хүүхдийг дагуулж ирж, дараах баримт бичгүүдийг үзүүлнэ*:

1P

Урилга захианы хамт

- Урилгад бүртгэлийн маягтыг хавсаргасан;
 - хүүхдийн нэрийг зааж өгсөн нэг албан ёсны баримт бичиг;
(иргэний үнэмлэх, гадаад паспорт, гэр бүлийн дэвтэр/гэрчилгээ, төрсний гэрчилгээ, Женевт амьдрах зөвшөөрлийн бичиг эсвэл Женев кантоны хууль ёсны үнэмлэх)
 - Эрүүл мэндийн даатгалтай гэсэн нотолгоо (LAMal);
(танай эрүүл мэндийн даатгалаас өгсөн гэрчилгээ эсвэл хүчин төгөлдөр даатгалын үнэмлэх)
- Хууль ёсны үнэмлэхтэй хүүхдүүд эцэг эхийн ажлаас олгосон эрүүл мэндийн даатгалд бүртгэлтэй гэсэн гэрчилгээг үзүүлэх боломжтой.*

1P- 8P: ЖЕНЕВТ ОРШИН СУУДАГ СУРАГЧИД

Урилга захидалгүйгээр

- Хүүхдийн нэрийг зааж өгсөн нэг албан ёсны баримт бичиг;
(иргэний үнэмлэх, гадаад паспорт, гэр бүлийн дэвтэр/гэрчилгээ, төрсний гэрчилгээ, Женевт амьдрах зөвшөөрлийн бичиг эсвэл Женев кантоны хууль ёсны үнэмлэх)
 - Эрүүл мэндийн даатгалтай гэсэн нотолгоо (LAMal);
(танай эрүүл мэндийн даатгалаас өгсөн гэрчилгээ эсвэл хүчин төгөлдөр даатгалын үнэмлэх)
- Хууль ёсны үнэмлэхтэй хүүхдүүд эцэг эхийн ажлаас олгосон эрүүл мэндийн даатгалд бүртгэлтэй гэсэн гэрчилгээг үзүүлэх боломжтой.*
- Түрээсийн гэрээ болон сүүлийн 3 сарын дотор олгосон “GIS” нэхэмжлэх;
 - Кантоны Хүн ам, Шилжин суурьшлын байгууллагаас (“ОСРМ”) хүүхдэд болон эцэг, эхийн аль нэгт эсвэл хүүхэдтэй хамт амьдарч байгаа хууль ёсны төлөөлөгчид олгосон сүүлийн гурван сарын доторх огноотой оршин суугчийн гэрчилгээ.х
- Хууль ёсны үнэмлэхтэй хүүхдүүд эцэг, эхийн ажил олгогчоос гэр бүлд олгосон Женев кантоны оршин суугчийн үнэмлэхийг үзүүлэх боломжтой. Энэ баримт бичиг нь түрээсийн гэрээ эсвэл “GIS” нэхэмжлэхийг орлоно.*

*нэмэлт баримт бичиг шаардаж магадгүй.